СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ, БҮТЦИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Улаанбаатар хот

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв нь 55 жилийн түүхт байгууллага бөгөөд анхны нэгж нь 1970 оны 7 дугаар сарын 1-ний өдөр “Хүүхдийн II эмнэлэг ” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

1. Хүүхдийн II больниц (1970-1980 он)
2. Сүхбаатарын районы Хүүхдийн нэгдсэн эмнэлэг (1980-1991 он)
3. “Сүхбаатар” Эрүүл мэндийн зөвлөх төв (1991-1997 он)
4. “Сүхбаатар” Эрүүл мэндийн нэгдэл (1997-2014 он)
5. “Сүхбаатар” дүүргийн Эрүүл мэндийн төв (2014-2025 он)

Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын даргын 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/82 дугаар тушаалаар ***“Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн Нэгдэл”*** нь ***“Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв”*** болж, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон бөгөөд 2024 он хүртэл үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөөгүй.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/123 дугаар тушаалаар батлагдсан дүрэм, бүтцийн дагуу 256 батлагдсан орон тоотой, үйл ажиллагаа явуулж байгаад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр Сэлбэ эмнэлэг ашиглалтад орж, Амбулатори шинээр ашиглалтад орсонтой холбоотойгоор НЭМГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/56 дугаар тушаалаар бүтэц, дүрэм, орон тооны хязгаарыг шинэчлэн батлуулсан бөгөөд одоогийн байдлаар 287 орон тоотой ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын 2026 оны төсвийн жил эхлэх гэж буйтай холбогдуулан “Сэлбэ” 200 ортой Нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тоог байгууллагын дүрэм, бүтцэд нэмж, шинэчлэн батлуулж, ЭМДЕГ-ын сонгон шалгаруулалтад оролцож, дараах тусламж, үйлчилгээгээр гэрээлэлт хийхээр төлөвлөлт хийсэн Насанд хүрэгчдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэс засал, гэмтэл, хавдрын хөнгөвчлөх, хими эмчилгээний хэвтүүлэн эмчлэх тасаг, хөнгөвчлөх, гемодиализийн өдрийн эмчилгээний тасаг, нэгжийг шинээр нээн ажиллуулж, алслагдсан хороодын хүн амд тусламж, үйлчилгээг ойртуулахаар.

Үйл ажиллагааны товч танилцуулга:

№	Төвийн барилга, байгууламж	Байршил	Үйл ажиллагааны чиглэл	Тайлбар
1.	Эрүүл мэндийн төвийн Төв амбулатори	СБД-ийн 11-р хороо Цагдаагийн гудамж	Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	- Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9070005009 - НЭМГ-ын Тусгай зөвшөөрлийн дугаар:ЭУ-07/22/3365 - ЭМЯ-аас 2024 онд 3 жилээр магадлан итгэмжлүүлсэн. **Батламжийн дугаар: 305/2023** - 12 алба, Төв амбулатори, Салбар амбулатори Сэргээн засах төвтэй. - Батлагдсан орон тоо -287 - ЭМДЕГ-тай 2025 оны 03 дугаар сард УБ-01/005-0004 дугаартай гэрээ байгуулсан. 10 дугаар сард УБ-01/005-414 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан.
2.	Сэргээн засах төв	СБД-ийн 17-р хороо Дамбадаржаа	Сэргээн засах тусламж үйлчилгээ	- НЭМГ-аас №:СЗТ-14/22-2/3611 дугаартай Сэргээн засах төвийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2023 оны 12 сарын 22-ны өдөр шинээр авсан. - 65 ортой - ЭМЯ-аас 2025 оны 04 дүгээр сард 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлсэн. **Батламжийн дугаар: 89/2025** - ЭМТ-ийн батлагдсан орон тоонд багтаан төвийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар 22 хүнийг томилж, хүний нөөцийг бүрдүүлсэн. - ЭМДЕГ-тай 2025 оны 05 дугаар сараас сэргээн засахын тусламж, үйлчилгээ худалдан авах УБ-02/122 дугаартай гэрээ байгуулж, 10 дугаар сард УБ-02/122-437 дугаартай нэмэлт гэрээ байгуулсан.
Шинээр				

3.	Нэгдсэн эмнэлэг	СБД-ийн 13-р хороо	Нэгдсэн эмнэлэг (200 ортой)	- Нэршил: Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сэлбэ эмнэлэг - НЭМГ-ын Тусгай зөвшөөрлийн дугаар: 2024/11/25-2027/11/25 - ЭМЯ-аас 2025 онд 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлсэн. **Батламжийн дугаар: 55/2025** - Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 2024 оны 06 дугаар сард ашиглалтад орсон - 2024 оны 10 дугаар сараас 2025 онд төрөлжсөн мэргэшлийн 16 чиглэлээр амбулатори, 14 төрлийн оношилгоо, шинжилгээ, Хүүхдийн 24 цагийн хүлээн авах, яаралтай тусламж, Хүүхдийн тасаг нээж ажиллуулсан. - 2025 оны 12 дугаар сард ЭМДЕГ-ын нэгдсэн сонгон шалгаруулалтад оролцож, 200 ортой хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, 35 ортой Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний тусламж, үйлчилгээг шинээр нээж, ажиллуулахаар төлөвлөсөн. Үүнтэй холбоотой Нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тоог нэмж, шинэчлэн батлуулах хэрэгцээ шаардлага үүссэн.
4.	Салбар амбулатори I	СБД-ийн 3-р хороо, Орос 3-р сургуулийн баруун талд	Төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээ үзүүлэх	- Үйл ажиллагаа түр зогссон. ЭМЯ/202001029 205 дугаартай гэрээгээр “Кенжикү” ХХК-аар барилгын ажлыг гүйцэтгэж, 2025 оны 08 дугаар сард Улсын комисс хүлээн авсан. - 2026 оны 01 дүгээр сараас үйл ажиллагааг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ХОЁР. ДҮРЭМ, БҮТЭЦ, ОРОН ТООГ ШИНЭЧИЛСЭН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Дүрэм:

1. Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, УИХ-аас шинээр баталсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох стандарт, тушаал, журамд нийцүүлсэн.
2. Одоогийн дүрмийн Нийтлэг үндэслэл хэсэгт байгууллагын нэршил “Сүхбаатар Эрүүл мэндийн төв” гэхийг “Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв” гэж өөрчлөн тушаалд нийцүүлсэн.
3. Төвийн үндсэн зорилго, чиг үүрэг хэсэг өөрчлөлт ороогүй.
4. Удирдлага, зохион байгуулалт, эрх үүрэг хэсэгт зохион байгуулалтын алба, тасаг, нэгжүүдийн чиг үүргийн давхардлыг арилгаж, нийтлэг болон тусгайлсан чиг үүргийг шинэчлэн тусгасан.

Хоёр. Бүтэц, Орон тооны хязгаар

№	НЭМГ-ын даргын 2024 оны А/56 дугаар тушаалаар одоогийн бүтэц, орон тоо		Шинэчлэн батлуулах бүтэц, орон тооны төсөл		Тайлбар
	Бүтэц	**Орон тоо**	**Бүтэц**	**Орон тоо**	
Удирдлага-5 орон тоотой					
1.	Эрүүл мэндийн төвийн дарга	1	Эрүүл мэндийн төвийн дарга	1	Өөрчлөлтгүй
2.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга	1	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга	1	
3.	Стратеги төлөвлөлт, үйл ажиллагаа хариуцсан орлогч дарга	1	**Үйл ажиллагаа хариуцсан орлогч дарга**	1	Нэршил өөрчлөгдсөн
4.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга	1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга	1	Өөрчлөлтгүй
5.	Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга	1	Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга	1	

6.	Дотоод хяналт-үнэлгээ	1	**Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ**	1	Нэршил өөрчлөгдсөн
12 Алба-133 орон тоотой					
7.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба	4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба	6	Шинэ эмнэлэг хариуцсан 1 орон тоо нэмсэн
8.	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба	9	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба	11	Сэлбэ эмнэлэг, салбар амулатори ашиглалтад орж үйл ажиллагаа өргөжүүлсэнтэй холбоотой орон тоо нэмсэн
9.	Захиргаа удирдлага, хүний нөөцийн алба	5	Захиргаа удирдлага, хүний нөөцийн алба	8	
10.	Халдвар судлаач нар	3	**Халдварын сэргийлэлт, хяналтын алба**	4	
11.	Даатгал, статистик мэдээллийн алба	7	Даатгал, статистик мэдээллийн алба	9	
12.	Сувилахуйн алба	3	Сувилахуйн алба	4	
13.	Эм зүйн алба	4	Эм зүйн алба	7	ЭМЯ, ЭМХТ, НЭМГ-ын Зөвлөмжийн дагуу Халдварын сэргийлэлт хяналтын албыг шинээр нэмсэн.
14.	Цахим систем, мэдээлэл, технологийн алба	11	Цахим систем, мэдээлэл, технологийн алба	15	
15.	Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн алба	5	Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн алба	6	
16.	Хангамж үйлчилгээ, аж ахуйн алба	29	Хангамж үйлчилгээ, аж ахуйн алба	39	
17.	Нийгмийн эрүүл мэндийн алба	6	Нийгмийн эрүүл мэндийн алба	8	
18.	Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх алба	18	Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх алба	16	ХЕЗохицуулагч, НҮЕЗохицуулагч нарыг НЭМА-руу шилжүүлсэн.
Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Төв амбулатори-103 орон тоотой (СБД 11 хороо)					
19.	Төв амбулатори	48	Төв амбулатори	58	ЭМС-ын Эрт илрүүлэг хийх бэлэн байдлын хүрээнд Дүрс оношилгоо, дурангийн эмч, сувилагч, аритугагчийн орон тоо,

					шинээр нэмэгдүүлсэн.
20.	Нэгдсэн лаборатори	18	Нэгдсэн лаборатори	20	Сэлбэ эмнэлэгт бактериологийн лаборатори шинээр нээхтэй холбоотой 1 эмч, 1 лаборант
21.	-	-	Салбар амбулатори	25	СБД-ийн 3-р хорооны нутаг дэвсгэрт 2025 онд шинэ барилгыг Улсын комисс хүлээж авсан.
Сэргээн засах төв-21 орон тоотой (СБД-17 хороо)					
22.	Сэргээн засах төв	21	Сэргээн засах төв	21	-
Сэлбэ эмнэлэг-177 орон тоотой (СБД-13 хороо)					
23.	Амбулатори	45		37	2025 оны 12 дугаар сард ЭМДЕГ-ын нэгдсэн сонгон шалгаруулалтад оролцож, 200 ортой хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, 35 ортой Хавдрын хөнгөвчлөх эмчилгээний тусламж, үйлчилгээг шинээр нээж, ажиллуулахаар төлөвлөсөн. Үүнтэй холбоотой Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу бүтэц, орон тоог төлөвлөсөн.
24.	Хүүхдийн тасаг	23		22	
25.	Дүрс оношилгооны тасаг	19		22	
26.	-	-	Хавдрын эмчилгээний тасаг	22	
27.	-	-	Дотор, мэдрэлийн тасаг	13	
28.	-	-	Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасаг	34	
29.	-	-	Мэс засал, гэмтлийн тасаг	25	
30.	Гэрээт ажилтан	3	Гэрээт ажилтан	2	
Нийт		**287**		**440**	

ГУРАВ. ХУУЛЬ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮНДЭСЛЭЛ

1. **Захиргаа, хүний нөөцийн алба нь:** Одоогийн бүтцэд “Захиргаа хяналт, шинжилгээ үнэлгээний алба” гэсэн нэршлээр байсныг хяналт-шинжилгээ үнэлгээний чиг үүргийг салгаж, нэршлийг шинэчлэн, чиг үүргийг дүрэмд шинэчлэн тусгасан. Хөдөлмөрийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 6 дугаар бүлэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2. **Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба**: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн “Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын алба” гэснийг шинэчилсэн.
3. **Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба:** Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/А/565 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дүрмийн 2.1.-т Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албыг байгууллагын даргын шууд удирдлагад хамаарагдана гэж заасны дагуу зохион байгуулсан. Тус алба нь дарга, чанарын менежер, аюулгүй байдал, эрсдэлийн менежер, лавлагаа мэдээллийн асуудал хариуцсан ажилтан, нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
4. **Халдварын сэргийлэлт, хяналтын алба:** ЭМС-ын 2014 оны Журам батлах тухай 186 дугаар тушаалын 1.4.4- дэх заалт, 2017 оны “ХСХ-ын тогтолцоог бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/169 дүгээр тушаал, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS5095:2017 стандартын 16.1.2-дахь заалттай нийцүүлсэн.
5. **Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ (Ахлах мэргэжилтэн):** МУЗГ-ын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор бүтцэд шинээр тусгасан. Гүйцэтгэх чиг үүргийг харгалзан МУЗГ-ын 2023 оны Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай 240-р тогтоолын 6 дугаар хавсралтын 6.4 дэх хэсэгт заасны дагуу “Ахлах мэргэжилтэн” гэж туссан зохицуулалттай нийцүүлсэн.
6. Стратеги төлөвлөлт, үйл ажиллагаа хариуцсан орлогч даргын шууд удирдлагад дараах нэгжүүд байна. Үүнд:
    - **6.1. Даатгал, статистик, мэдээллийн алба:** Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Статистикийн тухай хуулиар эрх, үүргийн хүрээнд байгууллагын эрүүл мэндийн даатгал, мэдээллийн асуудлыг хариуцан ажиллана.
    - **6.2.** Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба: Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 14.3, ЭМС-ын 2006 оны 12.29-ны 439 тоот тушаал “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн тасгийн бүтэц үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлагад нийцүүлэн орон тоог нэмэгдүүлж, албыг шинээр зохион байгуулсан.
    - **6.3. Хангамж, үйлчилгээ, аж ахуйн алба:** Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 14.5, 14.8, 15.1-т заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

6.4. **Цахим мэдээлэл, технологийн алба:** Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 14.6-дахь, Эрүүл мэндийн сайдын 2013 оны Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар дагаж мөрдөх журмын 2.2. дахь хэсгийг үндэслэв.

7. Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч даргын шууд удирдлагад дараах нэгжүүд ажиллана. Үүнд:

7.1. **Төв амбулатори:** Эрүүл мэндийн тухай хуулийн 16.10 дахь заалтыг үндэслэн өмнөх “бүтцэд батлагдсан “Поликлиник” гэсэн нэршлийг шинэчилж, Амбулатори” гэсэн нэршлээр бүтцэд тусгасан. Амбулаторид төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээ үзүүлж буй кабинетууд багтана.

7.2. **Салбар амбулатори I**: Дүүргийн 1-6 дугаар хорооны хүн амд үйлчлэнэ.

7.3. Эм хангамжийн алба: Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.12 дахь заалт

7.4. **Нэгдсэн лаборатори:** Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 12.1-т заасан үйлчилгээг үзүүлэх

7.5. **Сэргээн засах төв:** Эрүүл мэндийн тухай хуулийн 16.10-т ..... дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн эмнэлэг хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан зарим төрөлжсөн мэргэшлээр лавлагаа шатлалын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг нэмэлтээр үзүүлж болно гэж заасны дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 сарын 22-ны өдрийн Сүхбаатар эрүүл мэндийн төвийн дэргэдэх “Сэргээн засах төв”-ийн СЗТ-14/22-2/3611 тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр авсан тул бүтцэд тусгасан. Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 16.13, 3.1.21 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3.1.7 дахь заалттай нийцүүлсэн.

7.6. **Нэгдсэн эмнэлэг:** Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартад нийцүүлэн зохион байгуулсан. Үүнд:

7.6.1. Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2017 стандартын дагуу яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, хавдар, хөнгөвчлөх, дотор мэдрэл, хүүхэд, мэс засал, гэмтэл согог, сэтгэц, цус цусан бүтээгдэхүүн сэлбэлт, гемодиализ, хими эмчилгээ зэрэг мэргэшсэн тусламж үйлчилгээг үзүүлэх

7.6.2. Амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн кабинетууд;
Оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, уламжлалт анагаах ухаан, мэс засал, гэмтэл согог, эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүй, нүүр ам судлал, нүд судлал, чих, хамар, хоолой, хавдар, зүрх судас, дотор, мэдрэл зэрэг амбулаториор тусламж, үйлчилгээ үзүүлэх

7.6.3. Дүрс оношилгооны тасаг;
Рентген, хэт авиа, компьютер томограф, уян дурангийн болон бусад өөрийн тусламж, үйлчилгээний чиглэл, онцлогт хамаарах төрөлжсөн оношилгоог хийх

8. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч даргын шууд удирдлагад дараах нэгжүүд ажиллана. Үүнд:

8.1. **Нийгмийн эрүүл мэндийн алба**: Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.5, 8.1.6, 11.1.4, 11.2.3 , 13.2. дахь заалт, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 13.1-т заасан үйлчилгээг үзүүлэх

8.2. **Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэлтийн алба:** Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.2, 3.1.19, 13.2, 24.6.8 дахь заалт, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 14.1 дэх заалтыг тус тус үндэслэсэн.

9. Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч даргын шууд удирдлагад дараах нэгжүүд ажиллана. Үүнд:

9.1. **Сувилахуйн алба:** *ЭМС-ын 2015 оны "Дүрэм чиг үүрэг батлах тухай А/495 дугаар тушаал,* Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 12.1-т заасан үйлчилгээг үзүүлэх

9.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 4.1.6 дахь заалт, 12 дугаар зүйл, Сувилахуйн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6755:2019 стандарт*,* ЭМС-ын 2017 оны *"*Журам батлах тухай*" А/*381 дугаар тушаал*,* Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5095:2017 стандартын 12.2.2-т заасны дагуу нийцүүлсэн.

9.3. "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5095:2017 стандарт, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжүүлэх, энэхүү стандартай нийцүүлэн Нэгдсэн эмнэлэгт "Үйлчлүүлэгчдийг дэмжих алба" Эрүүл мэндийн төвийн бүтцийн нэгж болж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор эмнэлгээр үйлчлүүлсэн, үйлчлүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны үйлдэл, үйл ажиллагааны талаар гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, барагдуулах, эвлэрүүлэн зуучлах, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэх, үйлчилгээний соёл, ажилтны хувийн соёлыг дээшлүүлэх, удирдлагуудад мэдээллээр хангах, үйлчлүүлэгчийг чиглүүлэх, байгууллагын гадна болон дотор орчны тохижилтод анхаарах, ажилтнуудад сургалт явуулах зэрэг асуудлыг зохицуулах;

ХЯНАСАН: Б.БАЯРМАА, ЭМТ-ИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Э.ОЮУНСҮРЭН, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ДАРГА

А.АМАРЦЭНГЭЛ, СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ДАРГА

Б.ПҮРЭВЦЭЦЭГ, ЗАХИРГАА УДИРДЛАГА ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА

С.ӨСӨХБАЯР, СЭЛБЭ ЭМНЭЛГИЙН АМБУЛАТОРИЙН ЭРХЛЭГЧ